

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/154/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 261628 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Аудитор: Б.Давааням

Утас: 88095436 Цахим хаяг: Davaanuam@audit.gov.mn

Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн

Захирал, ахлах аудитор: Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: ikhermurun.audit@gmail.com

Чанарын хяналтын менежер: Ц.Мөнхтуяа

Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-11
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт.....	16-17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2022.02.24 № 01/146
танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Х.ТӨРМӨНХ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Хүнсний материал дансанд оны эхний үлдэгдэл 7.4 тонн 38.4 сая төгрөгийн махны үлдэгдэлтэй байхад тайлант онд нэмж 4.7 тонн 32.2 сая төгрөгийн махны худалдан авалт хийж үлдэгдлээр байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалттай нийцэхгүй *Нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Хүнсний материал данснаас 1.2 сая төгрөгийн 1035 кг байцаа, 1.0 сая төгрөгийн 994 кг төмс, 0.06 сая төгрөгийн 42 кг сонгино тус тус хөлдсөний улмаас ашиглах боломжгүй акталж устгасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалттай нийцэхгүй *Эрх ба үүрэг* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын хэрэгжилтийг шалгахад урсгал зардалд 44.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаж төвлөрүүлэхээс 7.8 сая төгрөг төвлөрүүлж бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.1 /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг

төлөвлөн хуваарилах / заалттай нийцэхгүй Нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 сарын 25 өдөр

№ 11/А2250433/ХӨА-2022/
154/АА-СН.А-ШШЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:



Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад урсгал зардалд 44,900,000/дөчин дөрвөн сая есөн зуун мянга/ төгрөгийн хэмнэлт гаргаж төвлөрүүлэхээс 7,800,000/долоон сая найман зуун мянга/ төгрөг төвлөрүүлж 37,100,000/гучин долоон сая нэг зуун мянга/ төгрөг төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх, үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 43 дугаар тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;
2. Цаашид Засгийн газрын тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн Захирал Х.Төрмөнх, нягтлан бодогч Г.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР
“ИХЭР МӨРӨН АУДИТ”ХХК-ИЙН
ЗАХИРАЛ  Б.МЯДАГМАА

172500001-9070605

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байрны А корпус 3 давхар 303 тоот, утасны дугаар: 7038 4043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 09 сарын 25 өдөр

№ 19/А.2250433/ТӨА-2022/
154/ТӨА-СНТ-ТМЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хүнсний материал дансанд оны эхний үлдэгдэл 38,434,750 /Гучин долоон сая дөрвөн зуун гучин дөрвөн мянга долоон зуун тавь/ төгрөгийн үнэ бүхий 7.4 тонн махны үлдэгдэлтэй байхад тайлант онд нэмж 32,240,000/Гучин хоёр сая хоёр зуун дөчин мянга/ төгрөгийн 4.7 тонн махны худалдан авалт хийж их хэмжээний нөөц үүсгэн төсвийг хэмнэлттэй төлөвлөж зарцуулаагүй байна


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-т “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хүүхдийн хоолны материал 7.4 тонн махны үлдэгдэл 32,240,000/Гучин хоёр сая хоёр зуун дөчин мянга/ төгрөгийг 2022 оны төсөвт зардлаас зарцуулалгүй улсын төсөвт буцаан төвлөрүүлж, зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цэцэрлэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн Захирал Х.Төрмөнх, нягтлан бодогч Г.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

“ИХЭР МӨРӨН АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ 

Б.МЯДАГМАА

1720090001 1 9070605

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байрны А корпус 3 давхар 303 тоот, утасны дугаар: 7038 4043

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>253,258,218.53</u>	<u>277,731,777.66</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	253,258,218.53	277,731,777.66
351	Түүхий эд материал	74,699,332.91	80,038,628.80
35110	Тусгай зориулалттай материал	70,606,998.91	76,166,506.80
35130	Эм боох материал	4,092,334.00	3,872,122.00
354	Хангамжийн материал	178,558,885.62	197,693,148.86
35410	Бичиг хэргийн материал	1,251,682.00	1,431,238.00
35420	Аж ахуйн материал	6,373,122.42	5,239,622.42
35440	Түлш, шатах тослох материал	5,630,190.00	3,791,550.00
35450	Барилгын засварын материал	10,153,550.00	22,093,500.00
35460	Хүнсний материал	62,035,966.00	55,346,270.00
35470	Бусад хангамжийн материал	93,114,375.20	109,790,968.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,202,844,987.32</u>	<u>1,396,591,241.66</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,202,844,987.32	1,396,591,241.66
392	Биет хөрөнгө	1,104,514,987.28	1,297,896,241.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,161,820,753.00	1,196,320,753.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-258,641,978.36	-347,888,212.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	202,465,358.04	274,393,806.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-145,660,420.24	-27,414,745.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	131,569,329.16	166,521,942.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-65,532,583.32	-42,919,731.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,705,700.00	37,705,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,620,053.80	-4,469,354.52
39217	Ном	45,408,882.80	45,646,082.80
393	Биет бус хөрөнгө	98,330,000.04	98,695,000.08
39301	Програм хангамж	6,887,000.00	7,085,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,406,999.96	-2,239,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	93,850,000.00	93,850,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,456,103,205.85</u>	<u>1,674,323,019.32</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,456,103,205.85</u>	<u>1,674,323,019.32</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,456,103,205.85	1,674,323,019.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,124,890,766.00	1,124,890,766.00
51101	Өмч: - төрийн	1,124,890,766.00	1,124,890,766.00
512	Хуримтлагдсан үр дүн	-471,543,016.89	-253,323,203.42
51210	Өмнөх үеийн үр дүн	-471,543,016.89	-471,543,016.89
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	218,219,813.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	802,755,456.74	802,755,456.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,456,103,205.85</u>	<u>1,674,323,019.32</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,688,325,316.91	1,766,390,106.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,501,016.91	230,003,780.41
120	Нийтлэг татварын бус орлого	89,501,016.91	230,003,780.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	89,501,016.91	17,158,529.13
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	89,501,016.91	17,158,529.13
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,598,824,300.00	1,536,386,325.63
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,393,123,500.00	1,313,060,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,843,600.00	23,652,025.63
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,010,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,491,425.63
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,843,600.00	4,150,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	198,857,200.00	199,673,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	198,857,200.00	199,673,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,644,511,847.67	1,548,170,292.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,644,511,847.67	1,548,170,292.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,487,384,210.67	1,503,978,982.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	944,166,104.00	939,349,538.00
210101	Үндсэн цалин	944,166,104.00	939,349,538.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,630,758.00	124,593,771.00
210201	Тэтгэврийн даатгал	81,060,567.00	96,441,893.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,434,254.00	7,043,111.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,547,404.00	5,634,489.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,868,041.00	1,406,753.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,720,492.00	14,067,525.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	185795501.00	190770881.00
210301	Гэрэл, цахилгаан	3,253,551.00	4,197,181.00
210302	Түлш, халаалт	177,526,150.00	180,223,700.00
210303	Цэвэр, бохир ус	5,015,800.00	6,350,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,574,490.00	34,831,597.63
210401	Бичиг хэрэг	1,940,240.00	1,773,247.63
210402	Тээвэр, шатахуун	5,281,440.00	10,276,740.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,000.00	965,000.00
210404	Ном, хэвлэл	6,722,000.00	300,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	412,000.00	1,924,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,894,600.00	5,196,522.00
210408	Бараа материал акталсны зардал	6,739,210.00	14,394,788.00
2105	Нормативт зардал	45,390,803.00	70,128,548.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,151,376.00	2,426,812.00
210502	Хоол, хүнс	42,846,987.00	67,452,236.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	392,440.00	249,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	803,750.00	7,370,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,363,000.00
210604	Урсгал засвар	803,750.00	6,007,150.00
2107	Томилолт, зочны зардал	921,000.00	968,400.00
210702	Дотоод албан томилолт	921,000.00	968,400.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,750,300.00	7,256,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,150,300.00	6,656,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	163,351,504.67	128,709,196.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,111,410.00	5,939,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	162,240,094.67	122,769,296.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157,127,637.00	44,191,310.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,429,400.00	36,351,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,316,900.00	36,351,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,112,500.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	97,519.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	97,519.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	137,698,237.00	7,742,191.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	137,698,237.00	7,742,191.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	43,813,469.24	218,219,813.47
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	43,813,469.24	218,219,813.47

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-515,356,486.13	1,412,289,736.61
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-515,356,486.13	1,412,289,736.61
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	26,403,604.33	26,403,604.33
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-471,543,016.89	1,456,103,205.85
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-471,543,016.89	1,456,103,205.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-471,543,016.89	1,456,103,205.85
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	218,219,813.47	218,219,813.47
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,124,890,766.00	802,755,456.74	-253,323,203.42	1,674,323,019.32

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,598,824,300.00	1,536,386,325.63
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,598,824,300.00	1,536,386,325.63
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,393,123,500.00	1,313,060,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,843,600.00	23,652,025.63
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	1,010,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	10,491,425.63
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,843,600.00	4,150,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	198,857,200.00	199,673,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	198,857,200.00	199,673,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,559,038,110.00	1,437,285,625.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,559,038,110.00	1,437,285,625.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,401,910,473.00	1,393,094,315.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	944,166,106.00	939,349,538.00
210101	Үндсэн цалин	771,227,406.00	627,122,686.00
210102	Нэмэгдэл	79,644,000.00	251,907,756.00
210104	Урамшуулал	93,294,700.00	60,319,096.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,630,756.00	124,593,771.00
210201	Тэтгэврийн даатгал	81,162,109.00	87,524,533.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,417,431.00	9,359,543.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,517,186.00	7,393,038.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,866,686.00	1,865,689.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,667,344.00	18,450,968.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	188,299,601.00	191,708,981.00
210301	Гэрэл, цахилгаан	3,253,551.00	4,197,181.00
210302	Түлш, халаалт	180,030,250.00	181,161,800.00
210303	Цэвэр, бохир ус	5,015,800.00	6,350,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,402,600.00	27,937,825.63
210401	Бичиг хэрэг	1,423,000.00	1,952,803.63
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,000.00	965,000.00
210404	Ном, хэвлэл	6,722,000.00	300,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,722,400.00	4,075,422.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,450,200.00	13,143,800.00
2105	Нормативт зардал	91,930,000.00	64,537,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,083,000.00	395,400.00
210502	Хоол, хүнс	65,780,300.00	63,062,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	20,066,700.00	1,078,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,424,700.00	17,730,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,724,000.00	7,473,200.00
210602	Тавилга	1,650,000.00	2,390,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,050,700.00	7,867,100.00
2107	Томилолт, зочны зардал	921,000.00	968,400.00

210702	Дотоод албан томилолт	921,000.00	968,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,750,300.00	8,909,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,150,300.00	8,309,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,385,410.00	17,359,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,385,410.00	17,359,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157,127,637.00	44,191,310.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,429,400.00	36,351,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,316,900.00	36,351,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,112,500.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	97,519.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	97,519.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	137,698,237.00	7,742,191.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	137,698,237.00	7,742,191.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	39,786,190.00	99,100,700.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	39,786,190.00	99,100,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	39,786,190.00	99,100,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	39,786,190.00	99,100,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,786,190.00	99,100,700.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-39,786,190.00	-99,100,700.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,512,734,300.00	1,504,894,590.00	7,839,710.00	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,512,734,300.00	1,504,894,590.00	7,839,710.00	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,472,924,400.00	1,468,542,990.00	4,381,410.00	99.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	941,169,000.00	939,349,538.00	1,819,462.00	99.8
210101	Үндсэн цалин	620,769,900.00	627,122,686.00	-6,352,786.00	101.0
210102	Нэмэгдэл	263,739,100.00	251,907,756.00	11,831,344.00	95.5
210104	Урамшуулал	56,660,000.00	60,319,096.00	-3,659,096.00	106.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,057,700.00	124,593,771.00	2,463,929.00	98.1
210201	Тэтгэврийн даатгал	89,411,000.00	87,524,533.00	1,886,467.00	97.9
210202	Тэтгэмжийн даатгал	9,411,700.00	9,359,543.00	52,157.00	99.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,529,400.00	7,393,038.00	136,362.00	98.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,882,300.00	1,865,689.00	16,611.00	99.1
210205	Эрүүл мэндийн даатгал	18,823,300.00	18,450,968.00	372,332.00	98.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	191,806,500.00	191,708,981.00	97,519.00	99.9
210301	Гэрэл, цахилгаан	4,330,000.00	4,197,181.00	132,819.00	96.9
210302	Түлш, халаалт	181,126,500.00	181,161,800.00	-35,300.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	6,350,000.00	6,350,000.00	00.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	25,044,500.00	25,044,500.00	00.00	100.0
210401	Бичиг хэрэг	1,400,000.00	1,452,800.00	-52,800.00	103.8
210402	Тээвэр, шатахуун	7,500,000.00	7,500,000.00	00.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.00	900,000.00	00.00	100.0
210404	Ном, хэвлэл	538,000.00	538,000.00	00.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,377,900.00	1,325,100.00	52,800.00	96.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,328,600.00	13,328,600.00	00.00	100.0
2105	Нормативт зардал	64,537,500.00	64,537,000.00	500.00	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	395,400.00	395,400.00	00.00	100.0
210502	Хоол, хүнс	63,062,900.00	63,062,900.00	00.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,079,200.00	1,078,700.00	500.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	94,346,500.00	94,346,500.00	00.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	53,911,400.00	53,911,400.00	00.00	100.0
210602	Тавилга	32,568,000.00	32,568,000.00	00.00	100.0
210604	Урсгал засвар	7,867,100.00	7,867,100.00	00.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	968,400.00	968,400.00	00.00	100.0
210702	Дотоод албан томилолт	968,400.00	968,400.00	00.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,498,800.00	2,498,800.00	00.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,898,800.00	1,898,800.00	00.00	100.0

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	600,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,495,500.00	25,495,500.00	00.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	25,495,500.00	25,495,500.00	00.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,809,900.00	36,351,600.00	3,458,300.00	91.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	00.00	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,809,900.00	36,351,600.00	3,458,300.00	91.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,809,900.00	36,351,600.00	3,458,300.00	91.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,512,734,300.00	1,504,894,590.00	7,839,710.00	99.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,313,060,700.00	1,305,318,509.00	7,742,191.00	99.4
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,313,060,700.00	1,305,318,509.00	7,742,191.00	99.4
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	199,673,600.00	199,576,081.00	97,519.00	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	199,673,600.00	199,576,081.00	97,519.00	99.9
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	00.00	100.0
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	82.00	82.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	46.00	46.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	35.00	35.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,652,025.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,652,025.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	23,652,025.63
2104	Хангамж, бараа материалын зардал	5,036,425.63
210401	Бичиг хэрэг	500,003.63
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	65,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,971,422.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,910,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,910,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6705000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,705,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	23,652,025.63
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	23,652,025.63
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,010,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,491,425.63
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,150,600.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хүүхдийн хоолны нормативт зардалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ихэр мөрөн аудит ХХК-ийн захирал, ахлах аудитор Б.Мядагмаа, аудиторын туслах Ж.Уранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Ц.Мөнхтуяа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд, дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургууль нь Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага бөгөөд 2021 онд багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулж, үр дүнд тулгуурласан хосолсон сургалтын хэлбэрийг хүүхдийн хөгжил, нас бие сэтгэхүйн онцлогт тохируулан явуулах, сургалтын сайн арга зүйг хэрэгжүүлж, хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэх тухай” тогтоол
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр “Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралт “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,644.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 32.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 26.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 218.2 сая төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансны үзүүлэлттэй холбоотой байна.

/Сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00	00	
Авлага	00	00	
Урьдчилгаа	00	00	
Бараа материал	253.3	277.7	24.4
Үндсэн хөрөнгө	1,202.8	1,396.6	193.8
Нийт хөрөнгө	1,456.1	1,674.3	218.2
Өр төлбөр	00	00	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,456.1	1,674.3	218.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,456.1	1,674.3	218.2

Бараа материалын дансны үлдэгдэл 277.7 сая төгрөг болж 24.4 сая төгрөгөөр буюу 8.8 хувиар өссөн байна. Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 127.4 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээж авсан 17.2 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж үйл ажиллагаанд 101.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Хөвсгөл аймгийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/27 дугаартай тушаалаар хөлдөж муудсан 2.3 сая төгрөгийн хүнсний материал, 12.1 сая төгрөгийн ашиглах боломжгүй болсон 81 ширхэг хангамжийн материал акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 1,396.6 сая төгрөг болж 193.8 сая төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна. Машин тоног төхөөрөмж дансанд 63.6 сая төгрөгөөр зөөврийн компьютер, принтер, үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд 2-р хоолны тогоо, тавилга эд хогшил дансанд архивын өрөөнд тавиур, номын сангийн өрөөний тавиур зэрэг 35.2 сая төгрөгийн хөрөнгийг Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авч бэлтгэсэн байна. Барилга байгууламж дансанд 34.5 сая төгрөгөөр хөргүүртэй контейнер Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, "0 үлдэгдэлтэй болсон боловч ашиглагдаж байгаа 89 нэр төрлийн 151.1 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн, өртгийг шинэчлэн 151.3 сая төгрөгөөр тогтоосон байна.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй 27 ширхэг 23.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан. Хуримтлагдсан элэгдэл дансанд 122.8 сая төгрөгийн өөрчлөлт гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,674.3 сая төгрөг болж 218.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 78.1 сая төгрөгөөр буюу 4.4 өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үзүүлэлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого данс байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг 1,548.2 сая төгрөгөөр толилуулсан нь өмнөх онтой харьцуулахад 96.3 сая төгрөгөөр буурч, нийт үр дүн 174.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

2021 оны төсвийг 1,417.5 сая төгрөгөөр төсөвлөн хүргүүлсэн байх бөгөөд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 01 дугаар тогтоолоор 1,418.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн явцад Цэцэрлэг сумын ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 01 тоот тогтоолоор 83.2 сая төгрөгийн тодотгол цалин, урамшуулалын зардалд, мөн тогтоолын 1- хавсралтаар орон нутгийн орлогоор 2.0 сая төгрөгийг урсгал засварын зардалд нэмэх тодотгол, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/121 дугаар захирамжаар нэмэх тодотголтой зохицуулалт хийж, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 9.4 сая төгрөгөөр төсвийг нэмэгдүүлж нийт 1,512.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийг 1,504.9 сая төгрөгөөр тайлагнасан нь батлагдсан төлөвлөгөө 1,512.7 сая төгрөгтэй харьцуулахад 99.5 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн 7.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд анхны батлагдсан төсөвтэй харьцуулахад хэмнэлт гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Боловсролын газраас ариутгалын зардалд 2.4 сая төгрөг, Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд 8.0 сая төгрөг, Ковид-19 цар тахалтай холбоотой нутгийн иргэдээс өгсөн хандив 1.0 сая төгрөг, Байгаль орчин мэдээллийн сургалтын төвөөс “Шимт хөрс” төслийн хүрээнд 7.5 сая төгрөг, түрээсийн номны төлбөр 3.9 сая төгрөг, БОАЖГ-аас зохион байгуулсан Ногоон суврага босгоё аяны хүрээнд 0.6 сая төгрөг, тендрийн хураамжийн орлого 0.2 сая төгрөг нийт 23.6 сая төгрөгийн орлогыг хүлээн авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторовын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны дотуур байрны хүүхдийн хоолны гүйцэтгэлийг шалгахад 1 хүүхдэд ногдох нормативт зардлыг 656.93 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулснаас нийт дүнгээр 10.7 сая төгрөгөөр зардал хэтэрсэн байгаа нь 2021 онд бензин шатахуун, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалж нэг хүүхдэд ногдох нормативт зардлын дүн өссөн байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.1.1-д “Нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг инфляцийн түвшин болон

суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан жил тутам шинэчлэн батлах” заалтын дагуу нэг хүүхдэд ногдох хоолны нормативтыг шинэчлэн батлуулах талаар дээд шатны байгууллагад саналаа хүргүүлэх шаардлагатай гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 онд нийт 2,667.0 сая төгрөгийн 78 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2,667.0 сая төгрөгийн 78 мэдээллийг ил тод байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны тухайд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан тасалбар болгосон ба тайланг батламжилсан өдрийн хооронд тайланд нөлөө үзүүлж болохуйц үйл явдал болоогүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 82.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 32.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 37.1 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 13.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

1. Хүнсний материал дансанд оны эхний үлдэгдэл 7.4 тн 38.4 сая төгрөгийн махны үлдэгдэлтэй байхад тайлант онд нэмж 4.7 тн 32.2 сая төгрөгийн махны худалдан авалт хийж үлдэгдэлээр байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалттай нийцэхгүй *Нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.3 Албан шаардлага

1. Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын хэрэгжилтийг шалгахад урсгал зардалд 44.9 сая төгрөгийн хэмнэлт гаргаж төвлөрүүлэхээс 7.8 сая төгрөг төвлөрүүлж бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.1 /үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах / заалттай нийцэхгүй *Нийцсэн ба зохистой* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.4 Зөвлөмж

1. *Нормативт зардалтай холбоотой асуудал*

1.1. Илрүүлэлт:

Дотуур байрны хүүхдийн хоолны гүйцэтгэлийг шалгахад 1 хүүхдэд ногдох нормативт зардлыг 656.93 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулснаас нийт дүнгээр 10.7 сая төгрөгөөр зардал хэтэрсэн байгаа нь хоолны зардлын норматив тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолын 2 дахь заалттай нийцэхгүй *Үнэлгээ ба хувиарлалт* батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг батлагдсан нормативийн дагуу зарцуулах.

2. *Бараа материалтай холбоотой асуудал*

2.1. Илрүүлэлт:

Хүнсний материал данснаас 1.2 сая төгрөгийн 1035 кг байцаа, 1.0 сая төгрөгийн 994 кг төмс, 0.06 сая төгрөгийн 42 кг сонгино тус тус хөлдсөний улмаас ашиглах боломжгүй акталж устгасан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалттай нийцэхгүй *Эрх ба үүрэг* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хүнсний ногоог бэлтгэн нийлүүлэгчээс гэрээнд заасан хуваарын дагуу татан авч, бараа материалын хадгалалт, ашиглалтанд тавих хяналтын сайжруулах.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын ерөнхий боловсролын сургууль	4	82.3	-	-	-	-	2	69.3	2	13.0

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо: 11/25

АЦДИТОР

Б.ДАВААНЯМ Огноо: 6/25

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

Ц.МӨНХТУЯА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

Б.МЯДАГМАА Огноо:

